



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2015 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Мэдээллийн технологийн талаар мөрдөх
журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн 140 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ НЬ:

1.Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээллийн технологийн талаар мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Уг журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллахыг Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзаяа/, Програмист /П.Энхтуяа/, Засвар үйлчилгээний ажилтан /Л.Бямбадорж/ нарт тус тус даалгасугай.

3.Мэдээллийн технологийн талаар мөрдөх журмын хэрэгжилттэй холбоотой гарах зардлыг бодож олгохыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

4.Байгууллагын мэдээллийн технологийн талаар мөрдөх журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг НЭМЭШСГХ-СМТА эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НАСАНЦЭНГЭЛ

00160